



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 7/2

Улаанбаатар хот

Түгээмэл тархацтай ашигт малтмалын
тусгай зөвшөөрлийн хувийн
хэрэг шилжүүлэн авах тухай

Монгол улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 01/2615 тоот чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль батлагдахаас өмнө Ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг орон нутгаас эргүүлэн татан авч хууль, тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг авч зохион байгуулж ажиллахыг Кадастрын хэлтсийн дарга / Д.Дашзэвэг /-т даалгасугай.

2. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын Эрдэс баялгийн салбарын асуудал хариуцсан орлогч дарга /М.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн а/127 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ХЭРЛЭН



Тушаал /А/

0000001